


# Дижитал хэрэглээний зээл авах заавар

## Leasing.golombank.com

### Зээлийн хүсэлт илгээх


#### Алхам 1

Харилцагч хамтран ажиллах гэрээ байгуулсан онлайн дэлгүүрээс сонгосон бараагаа сагсанд хийж, Голомт банкны зээлээр авах товчийг дарснаар Голомт банкны дижитал хэрэглээний зээлийн [leasing.golombank.com](http://leasing.golombank.com) вэбсайт рүү шилжинэ.




#### Алхам 2

Голомт банкны Дижитал хэрэглээний зээлийн [leasing.golombank.com](http://leasing.golombank.com) вэбсайт руу шилжсэнээр шаардлагатай хувийн мэдээллээ бөглөж "Үргэлжлүүлэх" товчийг дарна.




#### Алхам 3

Харилцагч зээлээр худалдан авах барааны дүн, хугацаа, шимтгэл, сарын төлөлт зэрэгтэй танилцаж, зээлийн хугацааг сонгоно. /Зээлийн хэмжээнээс хамааран хугацааны сонголт өөр байна/ Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа авахыг зөвшөөрч байна гэсэн хэсгийг сонгон "Үргэлжлүүлэх" товчийг дарна.




#### Алхам 4

Харилцагч зээлийн мэдээллийн сангийн лавлагааны хураамж 1000 төгрөг төлөх алхмыг гүйцэтгэнэ. Төлбөрийг өөрийн нэр дээрх карт болон SocialPay, Qpay зэргээр төлөх боломжтой.



#### Алхам 5

Лавлагааны хураамж амжилттай төлсний дараа харилцагч ДАН систем рүү өөрийн E-Mongolia-ийн эрхээр нэвтэрч, зээлийн судалгаанд ашиглагдах мэдээллүүдийг гаргаж өгөхийг зөвшөөрнө. Ийнхүү зээлийн хүсэлт амжилттай илгээгдэнэ.




#### Зээлийн шийдвэр шалгах

Харилцагчийн зээлийн судалгаа 1-5 минутын дотор амжилттай хийгдэх бөгөөд зээлийн шийдвэрийг банканд бүртгэлтэй гар утасны дугаарт илгээх ба [leasing.golombank.com](http://leasing.golombank.com)-ийн төлөв шалгах хэсгээс шалгах боломжтой.


## Алхам 6

Хүсэлт шалгах цэсэд регистрийн дугаараа оруулж "Үргэлжлүүлэх" товчийг дарна.




## Алхам 7

Регистрийн дугаараа оруулсны дараа банканд бүртгэлтэй гар утасны дугаарт 6 орон бүхий OTP код илгээх бөгөөд тухайн кодыг оруулснаар зээлийн шийдвэртэй танилцана.




## Алхам 8

Харилцагч зээлийн шийдвэр, нөхцөлтэй танилцан "Баталгаажуулах" товчийг дарна.




## Алхам 9

Зээл төлөх өдөр болон зээлийн шимтгэл төлөх дансыг сонгон баталгаажуулна.



## Алхам 10

Харилцагч Голомт банкны Интернэт банкны эрхээ оруулан баталгаажуулснаар зээлийн процесс амжилттай дуусна. Зээлийн гэрээ болон зээлийн график бүртгэлтэй и-мэйл хаягаар илгээгдэнэ.



Мөн салбар дэлгүүрт хандан зээлээр бараа бүтээгдэхүүн худалдан авах боломжтой. Салбар дэлгүүрээс худалдан авалт хийх тохиолдолд худалдааны зөвлөхөд хандан QR код бүхий нэхэмжлэх үүсгэнэ. Тухайн QR кодыг уншуулснаар Голомт банкны дижитал хэрэглээний зээлийн [leasing.golombank.com](http://leasing.golombank.com) вэбсайт руу шилжинэ.

